



БАТЛАВ.



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Нэг талаас “Чингис хаан” Олон улсын нисэх буудал (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Хос болор” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2017 оны 08 сарын 24-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын Төв байрны халаалт, цэвэр усны гадна төв шугамын хэсэгчилсэн засварын ажлыг (цаашид “ажил” гэх)-ийг нийт 35.060.000 ( гучин таван сая жаран мянган ) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх)-т гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн үнийн саналыг /НӨАТ орсон дүн/ үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу нийт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: 35.060.000 / гучин таван сая жаран мянга / Санхүүжилтийн эх үүсвэр нь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын өөрийн хөрөнгөөр.
4. Гүйцэтгэгч нь ажлыг 2017 оны 09 дугаар сарын 01-ны өдрөөс хуанлийн 30 хоногийн дотор хийж гүйцэтгэх бөгөөд ажлыг уг хугацаанд тасралтгүй, захиалагчийн тавьсан шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр 2 тал ажил гүйцэтгэж эхлэх өдрийг тогтоно.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 5.1 Гэрээний тусгай нөхцөл
  - 5.2 Гэрээний өрөнхий нөхцөл
  - 5.3 Тусгай зөвшөөрөл
  - 5.4 Ажлын төсөвГэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Захиалагч, гүйцэтгэгч нь энэ гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн захиалгыг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэсэн акт, зарлагын падаан, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ.

9. Захиалагч ажлын зөрчил гологдолтой гэж үзэх, зорчигч үйлчлүүлэгчдээс гомдол гаргах, хэрэглээний явцад чанарын шаардлага хангахгүй тохиолдолд ажлын гүйцэтгэлийг сайжруулах, сольж өгөх үүрэгтэй.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

Захиалагчийг төлөөлж:

Захиргаа, хүний нөөцийн  
ерөнхий менежер

С.Энхбаатар

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн  
хэлтсийн дарга

Ц.Эрдэнэчимэг

Дулаан, сантехникийн албаны дарга

Ж.Ганбаатар



Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Хос бөлөр" ХХК-ийн  
захирал

Н Нямсүрэн

### Талуудын албан ёсны хаяг

**Захиалагч:**

ХУД, 10-р хороо, Буянт-Ухаа дахь  
"Чингис хаан" ОУНБ

Утас: 283021, 283019 Утас:  
Факс: 70049617

**Нийлүүлэгч:**

УБ хот, БГД Энхтайвны өргөн  
чөлөө 125-213

Утас 99103066, 96654257

### Харилцах данс

**Захиалагч:**

Голомт банк 1301041321  
Худалдаа хөгжлийн банк 451004193

**Нийлүүлэгч:**

Голомт банк: 16021002  
Худалдаа хөгжлийн банк: 456089515

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1.Шалгах болон турших                            | Гүйцэтгэж буй ажил нь стандарт, техникийн шаардлага хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч ажлыг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д стандарт шаардлагыг заана.   |
| 2.Ажилны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | Ажил нь техникийн тодорхойлолт болон батлагдсан төсөвт нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.   |
| 3.Оюуны өмчийн эрх                               | Ажил, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон Гүйцэтгэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг Гүйцэтгэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4.Баталгаат хугацаа                              | Баталгаат хугацааг гэрээний тусгай нөхцөлд заана.   |
| 5.Гэрээнд өөрчлөлт оруулах                       | Гэрээний дагуу хийгдэх ажлын нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7.Ажил гүйцэтгэх хуваарь                         | Гүйцэтгэгч нь ажлыг тодорхой хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.<br><br>Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх явцад Захиалагч талаас чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор хяналт тавьж болно.  |
| 8.Алданги оногдуулах                             | Захиалагч Гүйцэтгэгчийн хугацаа хоцорч гүйцэтгэсэн ажлыг гэрээний үнийн дүнгээс ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна.<br>Захиалагч тал төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хувьтай тэнцэх хэмжээгээр алданги ногдуулж, гэрээний төлбөр дээр нэмж нэхэмжилнэ. |
| 9.Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг цуцалж, учирсан аливаа хохирлыг гэм буруутай тал нь барагдуулна.   |
| 10.Маргааныг шийдвэрлэх                          | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.   |
| 11.Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл                   | Ажил эхлэх өдрөөс ажил гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд хүн бэртэх, нас барах, түүнчлэн эд хөрөнгө алдагдах, эвдэрч гэмтэхээс үүдэн гарсан бөгөөд Захиалагчийн хүлээх эрсдлээс бусад эрсдлийг гүйцэтгэгч хүлээнэ.  |
| 12.Гэрээг цуцлах                                 | Захиалагч эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй  |

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |     |   |
|---|-----|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1)                            | 1.1 | Захиалагчийг төлөөлж Дулаан сантехникийн албаны ерөнхий инженер гэрээнд заасан ажлыг / нэр төрөл, тоо хэмжээ, чанар/ шалгаж, үзлэг хийнэ.<br>Хэрэв шалгах явцад чанарын шаардлага хангаагүй тохиолдолд Гүйцэтгэгч тал ажлыг сольж өгнө. |
| 2. Ажилны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1 | Гүйцэтгэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:<br>1) Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар<br>2) Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийн хувь<br>3) Гүйцэтгэлийн акт<br>4) Тусгай зөвшөөрөл<br>5) Гүйцэтгэсэн ажилтай холбоотой бичиг баримт                |
| 3. Төлбөр (ГЕН – 6)   |     | Гэрээний ерөнхий нөхцөлийн 6 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:  |
|   | 6.1 | Урьдчилгаа төлбөр болох гэрээний үнийн дүнгийн 40% -ийг нийлүүлэгчийн нэхэмжлэлийн дагуу гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш ажлын 5 хоногт багтаан шилжүүлнэ   |
|   | 6.2 | Гэрээний дагуу Гүйцэтгэсэн ажлыг бүрэн хүлээн авсан акт болон гэрээний нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн гэрээний үнийн 60% - тай тэнцэх дүнг ажлын 7 хоногт багтаан шилжүүлнэ                                    |
| 4. Алданги оногдуулах (ГЕН - 8)                             | 8.1 | Алданги оногдуулах хувь: 0,5  |
| 5. Баталгаат хугацаа (ГЕН - 4)                              | 4.1 | 36 сар  |